



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 22

Дархан

Зарим гэр хорооллын гудамжны
нэрийг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Монгол Улсын хаягжуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйл, Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Дархан сумын 3 дугаар багийн Тосгоны гудамж нэрийг хасч, уг гудамжийг Булагийн гудамжтай нэгтгэж, Булагийн гудамж гэж нэрлэх, 15 дугаар багийн Мангиртын 1-10 дугаар хэсэг, 7 дугаар багийн 017-гийн гудамжнуудын нэрийг хавсралтанд зааснаар өөрчлөн баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Хоёр. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Д.Ганбаяр/, сумын Засаг дарга /Б.Азжаргал/ нарт даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Болдбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.БАЛЖИННЯМ



Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдын
2017 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн
022 дугаар тогтоолын хавсралт



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМАНД
БАЙРЛАХ ГЭР ХОРООЛЛЫН ГУДАМЖНЫ НЭР

д/д	Баг	Гудамжны нэр	
		Хуучин	шинэ
1	Дархан сум 15 дугаар баг	1,3 дугаар хэсэг	Батальоны гудамж
2		2 дугаар хэсэг	Хүрээлэнгийн гудамж
3		4 дүгээр хэсэг	Овоотын гудамж
4		5,6 дугаар хэсэг	Ургацын гудамж
5		7 дугаар хэсэг	Нисэхийн гудамж
6		Хабитатын хэсэг	Талын толгойн гудамж
7		9 дүгээр хэсэг	Бэрх уулын гудамж
8		10 дугаар хэсэг	Асгатын гудамж
9	Дархан сум 7 дугаар баг	017-ийн гудамж	Баян уулын гудамж

---oO---